

БАТЛАВ
ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Ч.МӨНХТУЯА

2024 он 07 сар 06 өдөр

ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭ, ШАТАХУУН ХАНГАЛТЫН АЛБАНЫ ХЭРЭГЦЭЭНД ШААРДЛАГАТАЙ АВТОМАШИНЫ АККУМУЛЯТОРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны 2024 оны хэрэгцээнд шаардлагатай автомашин, механизмын аккумуляторт тавигдах техникийн шаардлага болон нийт тоо хэмжээг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Монгол улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын 05 дугаар хавсралтын 5.4 “Автомашин зай хураагуурын эдэлгээний хугацааны доод хязгаар жишиг норм”-ыг хангасан байна.

Мөн Монгол улсад албан ёсны борлуулагчтай үйл ажиллагаа явуулдаг эсэх зэргийг тодорхойлсон байх шаардлагатай.

2.1 Нийлүүлэгчид тавигдах шаардлага

- 2.1.1 Нийлүүлэгч нь тухайн чиглэлээр 2-оос доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай байна,
- 2.1.2 Нийлүүлэгч нь стандарт, шаардлагыг хангасан өөрийн агуулахтай байна,
- 2.1.3 Үйлдвэрийн болон тээвэрлэлтээс үүдэлтэй үүссэн гэмтэл, шинж чанарын өөрчлөлт зэргийг бүрэн хариуцана, зөрчлийг арилгана,
- 2.1.4 Нийлүүлэгчийн зүгээс чанарын баталгаатай байна,
- 2.1.5 Аккумуляторын техникийн үзүүлэлтийг харуулсан баримт бичгийг монгол хэл дээр ирүүлнэ

2.2 Аккумуляторт тавигдах шаардлага

- 2.2.2 Автомашинны аккумуляторын гүйлт нормыг автомашинд суурилуулсан өдрөөс эхлэн тооцдог тул 2024 онд үйлдвэрлэгдсэн, шинэ байх,
- 2.2.3 Аккумуляторт үйлдвэрлэсэн хугацаа тэмдэглэгдсэн байх,
- 2.2.4 Ашиглалтын явцад ямар нэг засвар үйлчилгээ хийдэггүй байх,
- 2.2.5 Хэт хүйтэн болон халуун хэмд шинж чанараа сайн хадгалдаг байх.

3. АККУМУЛЯТОРЫН ТОО ШИРХЭГ, ҮЗҮҮЛЭЛТ, БАГТААМЖ

Д/Д	Аккумуляторын багтаамж	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Тайлбар
1	70АН	ш	11	Шингэнт, шүлтийн, шонгийн байрлалыг захиалгын дагуу нийлүүлнэ.
2	90АН	ш	20	
3	100АН	ш	8	
4	120АН	ш	4	

5	200АН	ш	24	
	Нийт	ш	67	

4. ХҮЛЭЭН АВАХ

Нийлүүлэгч нь зөвхөн шаардлагад нийцсэн техникийн үзүүлэлтийг хангасан аккумуляторыг захиалгын дагуу нийлүүлнэ.

ИНЕГ-ын даргын тушаалаар томилогдсон ажил хүлээн авах комисс нь техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хүлээн авах актыг үйлдсэнээр аккумуляторыг хүлээн авсанд тооцно.

Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс актад гарын үсэг зурж, хүлээн авсанаас хойш 6 сар ба түүнээс дээш байна.

Ачааг хүргэх цэг: Улаанбаатар хот, Буянт-Ухаа, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албанд өөрийн тээврийн хэрэгслээр хүргэнэ.


Техникийн тодорхойлолт бэлтгэсэн:

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа
Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын
албаны ерөнхий инженер,
Үнэлгээний хорооны дарга:



Б. Гантулга

Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө
оруулалт, захиалагчийн албаны Худалдан
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн,
Үнэлгээний хорооны нарийн бичиг:



Б. Алтангэрэл

Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа
Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын
албаны Тээвэр ашиглалтын хэсгийн ашиглалтын
инженер,
Үнэлгээний хорооны гишүүн:



Л. Энхбаатар

“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв”
I өрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Б. Цагаан

“Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл”
Төрийн бус байгууллагын гишүүн,
Үнэлгээний хорооны хөндлөнгийн гишүүн:



Х. Энхбат

Улаанбаатар хот 2024 он